



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 181
танай _____ ны № _____ т

**ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА**

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 797,7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6,564.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030177



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/52/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenkhamg@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Төлбөрийн акт	17
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЗГ	Монгол Улсын засгийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 180

танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАТЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд бусдыгаа хошуучлан "Улсын тэргүүний сум шалгаруулах тухай" МУЗГ-ын 2022 оны 189 дугаар тогтоолоор улсын тэргүүний сумаар шалгарч гэрчилгээ, 100.0 (нэг зуун) сая төгрөгөөр шагнуулсан байна.

Аудитын гол асуудал

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ерөнхий боловсролын сургуульд 7,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Соёлын төвд 22,000.0 мянган төгрөгийн дээврийн засвар, Эрүүл мэндийн төвд 22,000.0 мянган төгрөгийн авто машиныг сумын Засаг даргын 2022 оны А/472 дугаар захирамжаар шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

008020213

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	108,707,121.33	114,201,877.50
33	АВЛАГА	1,049,271.00	6,494,027.17
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,569,742.17
335	Бусад авлага	1,049,271.00	4,924,285.00
3351	Байгууллагаас авах авлага	27,523.36	3,875,014.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,021,747.64	1,049,271.00
35	БАРАА МАТЕРИАЛ	107,657,850.33	107,707,850.33
354	Хангамжийн материал	107,657,850.33	107,707,850.33
35410	Бичиг хэргийн материал	-	50,000.00
35420	Аж ахуйн материал	7,315,150.00	7,315,150.00
35470	Бусад хангамжийн материал	100,342,700.33	100,342,700.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,560,219,736.74	2,831,965,940.31
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,560,219,736.74	2,831,965,940.31
392	Биет хөрөнгө	2,476,367,336.66	2,748,135,540.19
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,832,449,734.16	3,271,328,134.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,108,424,651.27)	(1,319,829,339.72)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,490,000.00	153,490,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,420,000.00)	(74,086,666.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,130,837.50	94,628,262.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,896,337.78)	(22,436,012.76)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51,422,836.15	62,760,936.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,329,488.49)	(28,516,738.96)
39209	Зам, гүүрийн байгууламж	564,774,695.00	564,774,695.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(86,888,414.64)	(130,332,621.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	239,159,642.00	240,007,642.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(93,101,515.97)	(103,652,749.56)
39217	Нөм	40,000,000.00	40,000,000.00
393	Биет бус хөрөнгө	83,852,400.08	83,830,400.12
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(43,999.92)	(65,999.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	83,676,400.00	83,676,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,668,926,858.07	2,946,167,817.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,925,817.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,925,817.28
413	Өглөг	-	2,925,817.28
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,430,817.28
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	495,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,668,926,858.07	2,943,242,000.53
51	Засгийн газрын хувь оролцоо	2,668,926,858.07	2,943,242,000.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	379,484,128.20	379,484,128.20
51101	Өмч: - төрийн	379,484,128.20	379,484,128.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,514,603,642.84	1,789,581,260.30

51210	Өмнөх үеийн үр дүн	1,514,603,642.84	1,515,266,117.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	274,315,142.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	774,839,087.03	774,176,612.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,668,926,858.07	2,946,167,817.81

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,735,399,772.00	1,173,294,280.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	971,824,187.00	393,664,890.00
120	Нийтлэг татварын бус орлого	971,824,187.00	393,664,890.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	971,824,187.00	393,664,890.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	318,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	971,224,187.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	763,575,585.00	779,629,390.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	107,672,385.00	180,826,714.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,077,000.00	-
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,500,000.00	53,855,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,621,385.00	123,096,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,474,000.00	3,875,014.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	655,903,200.00	598,802,676.55
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	655,903,200.00	598,802,676.55
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	626,436,418.47	849,479,138.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	626,436,418.47	849,479,138.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,410,252.32	814,257,402.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,893,800.00	255,986,991.95
210101	Үндсэн цалин	166,275,400.00	192,027,164.78
210102	Нэмэгдэл	57,620,600.00	31,766,273.54
210104	Урамшуулал	-	28,693,553.63
210105	Гэрээт ажлын хөлс	29,997,800.00	3,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,318,774.49	31,348,608.53
210201	Тэтгэврийн даатгал	22,178,878.08	20,347,820.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,534,998.67	2,191,142.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,027,999.28	1,850,115.53
210204	Ажилгүйдлийн даатгал	506,999.18	679,981.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,069,899.28	6,279,548.26

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,611,600.00	56,722,837.00
210301	Гэрэл, цахилгаан	5,160,000.00	7,071,237.00
210302	Түлш, халаалт	44,151,600.00	49,451,600.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,628,420.00	28,965,042.00
210401	Бичиг хэрэг	2,713,000.00	4,226,492.00
210402	Тээвэр, шатахуун	14,080,900.00	16,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,964,620.00	2,553,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,869,900.00	1,900,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,510,800.00	8,582,815.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,695,600.00
210604	Урсгал засвар	5,510,800.00	4,887,215.00
2107	Томилолт, зочны зардал	3,451,000.00	6,566,000.00
210702	Дотоод албан томилолт	3,451,000.00	6,566,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,105,785.00	26,979,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	24,522,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,500.00	293,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,487,000.00	-
210807	Газрын төлбөр	296,285.00	1,971,457.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	249,390,072.83	396,490,476.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,426,078.00	106,005,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	6,006,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	163,313,994.83	284,478,186.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,026,166.15	35,221,735.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	33,958,818.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	32,008,818.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,950,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,026,166.15	1,262,917.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,026,166.15	1,262,917.18
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	88,571,895.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	88,571,895.00	-
223001	Бусад хөрөнгө	88,571,895.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,108,963,353.53	323,815,142.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	154,675,448.07	49,500,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	101,544,080.63	49,500,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	53,131,367.44	-

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	865,716,010.46	274,315,142.46
---	-------------------------	----------------	----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	778,936,739.00	779,947,390.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,577,454.00	318,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,577,454.00	318,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	600,000.00	318,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	318,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,977,454.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,359,285.00	779,629,390.55
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,456,085.00	180,826,714.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,077,000.00	-
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,283,700.00	53,855,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	82,621,385.00	123,096,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,474,000.00	3,875,014.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	655,903,200.00	598,802,676.55
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	655,903,200.00	598,802,676.55
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	477,408,647.00	567,569,890.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,408,647.00	567,569,890.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	470,382,480.85	528,473,141.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,493,800.00	255,125,916.84
210101	Үндсэн цалин	165,875,400.00	191,166,089.67
210102	Нэмэгдэл	57,620,600.00	31,766,273.54
210104	Урамшуулал	-	28,693,553.63
210105	Гэрээт ажлын хөлс	29,997,800.00	3,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,346,297.85	31,348,608.53
210201	Тэтгэврийн даатгал	22,206,401.44	20,347,820.60
210202	Тэтгэмжийн даатгал	2,534,998.67	2,191,142.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,027,999.28	1,850,115.53
210204	Ажилгүйдлийн даатгал	506,999.18	679,981.28
210205	Эрүүл мэндийн даатгал	5,069,899.28	6,279,548.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,611,600.00	56,227,837.00
210301	Гэрэл, цахилгаан	5,160,000.00	7,071,237.00
210302	Түлш, халаалт	44,151,600.00	48,956,600.00

210303	Цэвэр, бохир ус	300,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,758,520.00	30,961,042.00
210401	Бичиг хэрэг	2,713,000.00	4,041,492.00
210402	Тээвэр, шатахуун	14,080,900.00	17,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,964,620.00	2,553,550.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	5,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,966,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,410,800.00	7,687,815.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,695,600.00
210604	Урсгал засвар	5,410,800.00	3,992,215.00
2107	Томилолт, зочны зардал	3,451,000.00	6,566,000.00
210702	Дотоод албан томилолт	3,451,000.00	6,566,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,105,785.00	42,838,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	40,380,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	170,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,500.00	293,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,487,000.00	-
210807	Газрын төлбөр	296,285.00	1,971,457.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,704,678.00	96,717,590.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,054,678.00	91,337,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	5,380,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,026,166.15	39,096,749.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	33,958,818.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	32,008,818.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,950,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,026,166.15	5,137,931.18
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	6,026,166.15	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,137,931.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	301,528,092.00	212,377,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	301,528,092.00	212,377,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	301,528,092.00	212,377,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	301,528,092.00	212,377,500.00
222001	Тоног төхөөрөмж	191,141,547.00	-
223001	Бусад хөрөнгө	110,386,545.00	212,377,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(301,528,092.00)	(212,377,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
----	---	---	---

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,484,128.20	775,558,956.88	648,167,762.53	1,803,210,847.61
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	379,484,128.20	775,558,956.88	648,167,762.53	1,803,210,847.61
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(85,617,388.00)	(85,617,388.00)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,484,128.20	774,839,087.03	1,514,603,642.84	2,668,926,858.07
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,484,128.20	774,839,087.03	1,514,603,642.84	2,668,926,858.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	662,475.00	662,475.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	379,484,128.20	774,839,087.03	1,515,266,117.84	2,669,589,333.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(662,475.00)	-	(662,475.00)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	274,316,442.46	274,315,142.46
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	379,484,128.20	774,176,612.03	1,789,582,560.30	2,943,242,000.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	600,574,900.00	597,857,759.37	2,717,140.63	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	536,974,900.00	534,257,759.37	2,717,140.63	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	502,966,000.00	500,298,941.37	2,667,058.63	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,454,200.00	255,125,916.84	1,328,283.16	99.5
210101	Үндсэн цалин	195,171,700.00	191,166,089.67	4,005,610.33	97.9
210102	Нэмэгдэл	52,062,100.00	31,766,273.53	20,295,826.47	61.0
210104	Урамшуулал	1,435,800.00	28,693,553.63	(27,257,753.63)	1,998.4
210105	Гэрээт ажлын хөлс	7,784,600.00	3,500,000.00	4,284,600.00	45.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,730,000.00	31,348,608.53	381,391.47	98.8
210201	Тэтгэврийн даатгал	21,576,300.00	20,347,820.60	1,228,479.40	94.3
210202	Тэтгэмжийн даатгал	2,535,400.00	2,191,142.86	344,257.14	86.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,030,800.00	2,191,142.86	(160,342.86)	107.9
210204	Ажилгүйдлийн даатгал	507,700.00	679,981.28	(172,281.28)	133.9
210205	Эрүүл мэндийн даатгал	5,076,800.00	6,279,548.26	(1,202,748.26)	123.7

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,920,700.00	56,227,837.00	692,863.00	98.8
210301	Гэрэл, цахилгаан	7,160,000.00	7,071,237.00	88,763.00	98.8
210302	Түлш, халаалт	49,460,700.00	48,956,600.00	504,100.00	99.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	200,000.00	100,000.00	66.7
2104	Хангамж, бараа материалын зардал	29,461,600.00	29,461,042.00	558.00	100.0
210401	Бичиг хэрэг	4,045,600.00	4,041,492.00	4,108.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	15,900,000.00	15,900,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,616,000.00	2,553,550.00	62,450.00	97.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	5,000,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,900,000.00	1,966,000.00	(66,000.00)	103.5
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,555,600.00	31,547,815.00	7,785.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	27,555,600.00	27,555,600.00	-	100.0
210604	Урсгал засвар	4,000,000.00	3,992,215.00	7,785.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	6,570,000.00	6,566,000.00	4,000.00	99.9
210702	Дотоод албан томилолт	6,570,000.00	6,566,000.00	4,000.00	99.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,707,000.00	2,457,632.00	249,368.00	90.8
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	170,775.00	129,225.00	56.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	344,000.00	293,400.00	50,600.00	85.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	22,000.00	44,000.00	33.3
210807	Газрын төлбөр	1,997,000.00	1,971,457.00	25,543.00	98.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,566,900.00	86,564,090.00	(997,190.00)	101.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,566,900.00	85,564,090.00	2,810.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,008,900.00	33,958,818.00	50,082.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,008,900.00	33,958,818.00	50,082.00	99.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,008,900.00	32,008,818.00	82.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,950,000.00	50,000.00	97.5
2200	Дотоод эх үүсвэрээр	63,600,000.00	63,600,000.00	-	100.0
223001	Бусад хөрөнгө	63,600,000.00	63,600,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	600,574,900.00	597,857,759.37	2,717,140.63	99.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	499,374,000.00	597,539,759.37	(98,165,759.37)	119.7
132001	Орон нутгийн төсвөөс	499,374,000.00	597,539,759.37	(98,165,759.37)	119.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	101,200,900.00	318,000.00	100,882,900.00	0.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	318,000.00	282,000.00	53.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	100,600,900.00	-	100,600,900.00	-
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	-	100.0

620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	180,826,714.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	180,826,714.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	176,951,700.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,371,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,371,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,080,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,380,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,875,014.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3,875,014.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,875,014.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	180,826,714.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,826,714.00
131103	ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,633,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	105,318,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,875,014.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газар эрхэм зорилгоо “Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан, шуурхай, чанартай хүргэж, төрийн захиргааны манлайлагч байгууллага байх нь бидний эрхэм зорилго” гэж тодорхойлжээ.

Тайланд оныг “Иргэдээ сонсох жил болгон” зорилт дэвшүүлэн “жил бүр оновчтой төлөвлөлт хийж, гүйцэтгэлийн үр нөлөө бүтээмжийг дээшлүүлж, сум орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах замаар иргэдийнхээ хөгжих боломжийг

хангаж, амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэн, төрийн үйлчилгээг стандартад нийцүүлэн чанартай хүргэх бодлого баримтлан ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 277,241.0 мянган төгрөгөөр буюу 10.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	(мянган төгрөгөөр)		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,049.30	6,494.00	5,444.70
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	107,657.80	107,707.90	50.10

Үндсэн хөрөнгө	2,560,219.70	2,831,965.90	271,746.20
Нийт хөрөнгө	2,668,926.80	2,946,167.80	277,241.00
Өр төлбөр	-	2,925.80	2,925.80
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,668,926.80	2,943,242.00	274,315.20
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,668,926.80	2,946,167.80	277,241.00

Эх сурвалж: Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд өссөн байна.

Засаг даргын тамгын газрын их засвартай холбоотой тохижилтод 29 нэр төрлийн 17,279.2 мянган төгрөгийн аж ахуйн материалын худалдан авалт хийгдсэн байна.

Сумын Засаг даргын 2022 оны А/472 дугаар захирамжаар ОНХС-аар хийгдсэн 20 нэр төрлийн 393,346.9 мянган төгрөгийн зам гүүрийн байгууламж, малын угаалгын хашаа, ванн, тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж гэх мэт хөрөнгийг орлогод авч тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 526,671.2 мянга, өөрийн орлогоос 600.0 мянган төгрөг нийт 527,271.2 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаар зардлыг 73,303.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, өөрийн орлогоос 600.0 мянга, орон нутгийн төсвөөс 599,974.9 мянган төгрөгөөр нийт 600,574.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд 1 удаа тодотгол хийгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр өөрийн орлого 318.0 мянга, орон нутгийн төсвөөс 597,539.8 мянган төгрөг нийт 597,857.8 мянган төгрөгийг санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 597,857.8 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа, баг хорооны үйл ажиллагаа, АО-оос олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 2,717.1 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
	код	Нэр				
1	70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	600,574.90	597,857.80	2,717.10	99.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	361,566.60	359,374.60	2,192.00	99.4
1.2	80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	58,437.60	57,965.40	472.20	99.2
1.3	80112	Нийтлэг үйлчилгээ	11,960.90	11,960.90	-	100.0
1.4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,000.00	1,950.00	50.00	97.5
1.5	80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчдад олгох нөхөн олговор	32,008.90	32,008.80	0.10	100.0
1.6	80918	Бусад хөрөнгө	63,600.00	63,600.00	-	100.0
1.7	81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	61,000.90	60,998.10	2.80	100.0

1.8	82212	Хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	5,000.00	5,000.00	-	100.0
1.9	82801	Улсын баяр наадам	5,000.00	5,000.00	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 180,826.7 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

(мянган төгрөгөөр)

№	Эх үүсвэр, зориулалт	Мөнгөн дүн
1	Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас улсын тэргүүний сумын шагналд	100,000.00
2	Аймгийн Статистикийн хэлтсээс хөдөө аж ахуйн тооллогын зардал, багийн засаг дарга нарт сурталчилгааны зардалд, ХАА-н ээлжит тооллогын зардалд	5,318.70
3	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх зардалд, морин эргүүлийн урамшуулалд, отоглох цэг байгуулах зардалд, гамшгийн эрсдэлээс бууруулах зардалд, байгалийн гамшгийн эрсдэлээс бууруулах арга хэмжээний зардалд, цэвэр орчин цэмцгэр булган аяны зардалд	30,364.00
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-ын их засварын зураг төсвийн зардал, эрэн хайх аврах бүлгийн байрны засварын зардалд	36,889.00
5	Аймгийн Засаг даргын тамгын газраас аймгийн Засаг даргын А/57 дугаар захирамжаар хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 1-р байр эзэлсэн шагналд	4,380.00
6	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,875.00
Нийт дүн		180,826.70

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/24 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 790,526.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,857.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,893.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/126 дугаар албан тоотой тус тус ирүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	17,687.9	1	17,687.9	100.0
Зөвлөмж	3	-	3	-	100.0
Нийт дүн	4	17,687.9	4	17,687.9	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдэлд бүрэн тооллогын горим сорил хэрэгжүүлэн, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 2022 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд дурдсан зүйлсийг шийдвэрлэсэн байдал зэргийг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31,348.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 31,348.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Цалингийн зардлыг тооцоолсон цалингаар тооцооны дансаар дамжуулаагүй, НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэснийг залруулсан.

Аудитаар нийт 7,361.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 797.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 6,564.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Цалингийн зардлаас сумын ЗДТГ-ын 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогч Ц.Булганцэцэгт нэг сарын үндсэн цалингаар балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” заалтыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгохгүй байх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207, 39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг /-1, 0/ буруу тайлагнасан хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Сангийн сайдын элэгдэл тооцох журмыг баримтлан, үнэн зөв тооцож, ашиглалтын хугацааг үнэн зөв бүртгэж, тайлагнах.

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын тайланд, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн материал үндсэн хөрөнгийн тайланд бүртгэлтэй байна. Мөн хөрөнгийг нэг бүрчлэн задалж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал, үндсэн хөрөнгийн тайлангийн дансны ангиллыг үнэн зөв бүртгэж, бөөн дүнгээр авсан орлогыг хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ бүрээр задалж орлого авч хэвших зөвлөмж өгөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
тооцоолсон цалинг тооцооны дансаар дамжуулаагүй	1	31,348.6			1	31,348.6						

НДШ, ХХОАТ, бусад өглөгийг шууд зардлаар бүртгэсэн.													
Дүн	1	31,348.6			1	31,348.6							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Цалингийн зардлаас сумын ЗДТГ-ын 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогч Ц.Булганчимэгт нэг сарын үндсэн цалингаар балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	1	797.7	-	-	1	797.7	-	-	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалын тайланд, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн материал үндсэн хөрөнгийн тайланд бүртгэлтэй байна. Мөн хөрөнгийг нэг бүртчлэн задалж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн байна.	1	6,564.2	-	-	-	-	1	6,564.2	-	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн тайланд 39205, 39214, 39305, 39207,39201 дансанд 32 нэр төрлийн ашиглалтын хугацааг /-1, 0/ буруу тайлангасан хөрөнгө бүртгэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	3	7,361.90	-	-	1	797.70	2	6,564.20	-	-	-	-	-



БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 01/155

Булган сум

А0640253

БНА-2023/52/НА-ТМЗ-СТА

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хутаг-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас сумын ЗДТГ-ын 2022 оны Б/12 дугаар тушаалаар нягтлан бодогч Ц.Булганчимэгт нэг сарын үндсэн цалин 797,676.0 (долоон зуун ерэн долоон мянга зургаан зуун далан зургаа) төгрөгийн балансын урамшууллыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" заалтыг баримтлаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон алдаа зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт нотлох баримтын хамт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хутаг-Өндөр сумын сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Батцэцэг), нягтлан бодогч (Н.Мягмаржаргал) нарт даалгав.

006040500

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

~~Б.ЭРДЭНЭ~~
~~Ж.ЭНХЦООДОЛ~~
Г.ЦЭРЭНЛХАМ

J. *Wojcik*



6317144736
ГНОА0048 3190369